

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 23-ны өдөр

Дугаар...

БА-061/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 2 давхар, 1 блок 280 (хоёр зуун наяд) хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2022 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/06/02 огноо, 0012863 дугаар, БАЗГ2023/292;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар Шифр: БП-04/72;

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9011122089 улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2659603 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын гудамж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилга Б блок, 11-327199 холбоо барих утас, www.ulaanbaatar.mn цахим шуудангийн хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: "Хөхий Хан" ХХК оноосон нэр, 9011057139 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2708515 регистрийн дугаар, БУ18-118/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж VVV center 303 тоот, 76116969, 99094619, 99032699 холбоо барих утас, khukhiikhan.2002@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: "Шонхорчин" ХХК оноосон нэр, 9011093083 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5131189 регистрийн дугаар, БУ18-746/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Нутгийн буян байр 103тоот, 99104397, 70114377, 88110222.

"Мачу мандал" ХХК оноосон нэр, 9011843999 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6927866 регистрийн дугаар, 12100687 харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн дугаар,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 9 дүгээр хороо, Баруун баян уул 14, 54-тоот, 99046960 холбоо барих утас;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Батпроект ХХК оноосон нэр, 9011113047 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2773643 регистрийн дугаар, ЗТ19-583/22 зураг төслийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруу 26, 1-213 тоот 99249997, 99240054 холбоо барих утас;

Дукат ХХК оноосон нэр, 9011177089 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5277965 регистрийн дугаар, ЗТ16-29/22 зураг төслийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 220 мянгат, 24-64, 91999993 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн Боловсролын газар оноосон нэр, 9070003041 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9077065 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Багшийн хөгжлийн ордон, 70113039 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**


Гурав. Дүгнэлтийн хэсэг

- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
 - Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 2 давхар, 1 блок 280 (хоёр зуун ная) хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын зориулалттай барилга байгууламжид түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:



а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 2 давхар, 1 блок 280 (хоёр зуун ная) хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, зорьгүй 2 давхар, 1 блок 280 (хоёр зуун ная) хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн
хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 14 ДҮГЭЭР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 2 ДАВХАР, 1 БЛОК, 280 ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГ, БАГА СУРГУУЛИЙН ЦОГЦОЛБОРЫН ЗОРИУЛАЛТТАЙ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

Хан-уул дүүргийн 14 дүгээр хороонд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай зоорьгүй 2 давхар, 1 блок, 280 хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 11:00 цагт 12 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 12:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ Барилга захиалагчийн хэлтсийн ахлах инженер Б.Намсрайжав
3. Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Шинэжаргал
4. Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
5. Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн техник хяналтын инженер Б.Цэрэннадмид
6. Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ
7. Нийслэлийн Онцгой байдлын газар, барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, хошууч Б.Даваасүрэн
8. Үндэсний төв архивын газар, зураг төслийн баримтын архивын ахлах архивч Э.Шижиртуяа
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан Б.Ганбаатар
10. Гүйцэтгэгч байгууллага: “Хөхий Хан” ХХК-ийн захирал Г.Дагвасамбуу
11. Ашиглалт хариуцах байгууллага: Нийслэлийн боловсролын газрын Санхүү хөрөнгө оруулалтын тасгийн Барилга хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Д.Ирмүүнзаяа

12. Зураг төсөл зохиогч байгууллага: Батпроект ХХК-ийн инженер
Дукат ХХК-ийн ерөнхий инженер

Н.Наранчимэг
Д.Сэргэлэнбаатар

ХЯН
Барилга ба

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 12
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 12

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 14 дүгээр хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, зоорьгүй 2 давхар, 1 блок, 280 хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын зориулалттай барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Б.Шинэжаргал:**

- Барилгад ашигласан тохирлын гэрчилгээ шалгуулах
- Улаан журнал, ид далд ажлын акт үзүүлэх
- Барилга угсралтын ажил ямар шалтгаанаар зогссон, хамгаалалтын горимд оруулсан тухай тайлбар ирүүлэх
- Спорт заалны дээврийн борооны ус зайлуулах хоолой хийх
- Зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн бичиж шалгуулах
- Чанарын баталгааны албан бичиг ирүүлэх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Бохир усны цооногт шат хийх
- Гадна худаг хүзүү өндөрлөх
- Бохир усны шугаманд халаах кабель угсрах
- Уурын зууханд ашиглалтын паспорт хяналтын улсын байцаагчаар баталгаажуулж авах
- Зуухны шугаманд ус буулгагчууд угсрах
- Зуухны түлшний өрөөний агаар сэлгэлт бүрэн угсрах
- Зуухны тогооны аюулгүйн ажиллагааны зааварчилгааг ойлгомжтой хийх
- Халаах хэрэгсэлд зөөлөвч булан хийх, цонхнуудад хязгаарлагч хийх
- Гадна дулааны худагт ус буулгагч хаалтны эсрэг талд угсрах худагтшат хийх
- Сургуулийн узелийн өрөөнд ус зайлуулах трап хийх

- Усны нөөцийн сав ариутгах, Цэвэр усыг шинжилгээнд оруулан эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах
- Агаар сэлгэлтийн решотикнууд зөв харуулан угсрах
- Барилгын агаар сэлгэлтийн механик системүүдийн удирдлагын самбар хаягжуулах
- 00 өрөөний угаагуурын сифон хоолойг усан хаалттай болгох
- Үнс хадгалах битүү сав хийх
- Шалны халаалтын залгуурт унтраалга хийх
- Дээвэр дээр агаар сэлгэлтийн шахт

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- Цахилгааны өрөөний хаалгад хаяг бичиг, плакат хийх
- ЕОС-1,2-т ажлын зургийн дагуу ерөнхий автомат, ОПС цэнэг шахагч тавих
- Давтан газардуулгын хүрээг зэврэлтээс хамгаалж будах
- Цэцэрлэгийн ерөнхий самбар болон уурын зуухны 0,4Кв-ын ЦДКШ-г НМС-д бүртгүүлэх
- Уурын зуухны цахилгаан тоноглолуудыг хүрээ газардуулгад бүрэн холбох
- Дизель генераторыг АЗБТ-ын ш/х-т бүртгүүлж, шуурхай ажиллагааны гэрээ хийх
- Дизель генераторыг 2-оос доошгүй цэгээр давтан газардуулах
- Гүйцэтгэлийн актуудыг гарын үсэг, тамга тэмдэгээр бүрэн баталгаажуулах
- Угсралтын ажил гүйцэтгэсэн Шонхорчин ХХК-ийн тусгай зөвшөөрөл шалгуулах

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК-ий Удирдлага төлөвлөлтийн газрын дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Дотор холбоо дохиоллын ил далд ажлын актуудыг цэцэрлэг, сургуулиар салгаж үйлдэх
 - Давхар дундын салбарууд болон сүлжээний утаснууд холбооны өрөөг хаягжуулах
 - Сургуулийн хяналтын камерийн бичлэгийг доод тал нь 1 сар хадгалдаг байхаар хард суурилуулах
 - Дотор холбоо дохиолол угсарсан компанийн тусгай зөвшөөрөл, гэрээ шалгуулах
- Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, хошууч **Б.Даваасүрэн:**

- Гадна дулаалга болон дээврийн сендвич дүгнэлт
- ГК холбох тотго комут солих, ус тавьж шалгах, тэмдэглэгээ хийх
- Галын дохиоллын систем шалгасан акт фото зураг, зааварчилгаа байршуулах
- Автор-с аваарын гарцтай холбоотой тайлбар ирүүлэх

- Спорт заалны дээврийн ус зайлуулах хоолой хийх
- Аваарын шат буух хэсэгт цонхонд хаалт хийх
- Уурын зуухны барилга зай хэмжээ хэмжих тайлбар ирүүлэх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Архивын ерөнхий газар, Зураг төслийн баримтын архивын Ахлах архивч

Э.Шижиртуяа:

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах
- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэж өгөх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Нийтийн авто зогсоолд ХБХ-ний машинд зориулсан зогсоолын өргөн 3м95см машин зогсох зай 2м 45см тэргэнцэртэй бууж суух зай 1м50см эрээн шугам татаж тусгаарлаж өгнө. Зогсоолын урд 1м80см шон 30х45 багагүй багагүй самбар байгуулна.
- Гадна налуу замын бариулын өргөн 3см ихгүй болгож өөрчлөх
- Ажилчдын ариун цэврийн өрөөний суултуур, угаалтуур, шүршүүрт БНБД 31-23-22 стандартын шаардлага хангасан туслах тоноглолыг суурьлуулна.

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн

Д.Ирмүүнзаяа:

- Цэцэрлэгийн угаалга, хатаалгын өрөөнд бохирын гаргалгаа гаргах
- Гал тогоонд 3 дамжлагат угаалтуур, тос баригч хийж өгөх
- Сургуулийн гал тогоо хооллох хэсэгт хаалт хийх
- Спорт заалны тоноглол хийх
- Спорт зааланд цонхны хаамгаалалт хийх
- Хувцас солих өрөөнд душны хаалт хийх
- Тоглоомны талбайн тохижилт хийж дуусгах
- Үүдний ус буух яндан шилжүүлж өөрчлөх
- Барилгын холбогдох баримт бичиг 1% ашиглагчид хүлээлгэж өгөх, барилгын хувийн хэрэг үүсгэж өгөх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ, Төвийн бүсийн ахлах инженер:
Б.Намсрайжав

- Гадна ногоон байгууламж дулааны улиралд хийж гүйцэтгэх
Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч байгууллага: Батпроект ХХК-ийн инженер **Н.Наранчимэг:**

- Цэцэрлэгийн эрхлэгч, оффисын өрөөний халаат муу байгааг засах
Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч байгууллага "Хөхий Хан" ХХК-ий захирал **Г.Дагвасамбуу:**

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан бичгээр ирүүлэх
- Төсөвт тусгагдсан 1570.31м² зүлэг тарих ажлыг гүйцэтгэх хугацаа заасан баталгааг албан бичгээр захиалагчаас ирүүлэх
- Спорт заалны дээврийн ус зайлуулах системийг бүрэн дуусгах фото зургаар баримтжуулж ирүүлэх
- Зураг төсөл зохиогчийн төлөөлөл Н.Наранчимэгийн итгэмжлэлийг шинэчилж ирүүлэх
- Нийтийн эзэмшлийн талбайд байрлах багана, ирмэг буланд хүүхэд бэртэхээс сэргийлж хамгаалалт хийх /халаах хэрэгсэлд/
- Аваарын гарц, гадагш гарах /шилэн/ хаалга хагарах хүүхэд бэртэхээс сэргийлсэн арга хэмжээ авах
- Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээг сунгуулаагүй, хүчинтэй хугацаанд ашиглалтанд оруулаагүйд захиалагчаас тайлбар албан бичгээр ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 14 дүгээр хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, зоорьгүй 2 давхар, 1 блок, 280 хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн **анд** цогцолбор барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ, Барилга захиалагчийн хэлтсийн дарга



(Б.Ганзориг)